



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/04

Хөхбүрд

2025 оны цэргийн тоон бүртгэл явуулах тухай

“Цэргийн албаны тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, Батлан хамгаалахын сайдын “Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай” 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан журам, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/747 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны цэргийн тоо бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 10-ны өдрүүдэд явуулсугай.

2. Цэргийн тоон бүртгэлийг явуулах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Т.Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

З.Ёндонжамц (Улсын бүртгэгч)

Ц.Бямбасүрэн (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Р.Содном (Цагдаа)

3. Сумын хэмжээнд цэргийн насны 18-50 эрэгтэйчүүдийг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгах нь:

а. Цэргийн бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль,

642401169

эрх зүйн баримт бичгүүдийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулах,

б.Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын дагуу цэргийн бүртгэлээр ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нууц хадгалалт, хамгаалалтыг чанд сахиж, Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг хүн нэг бүрээр гаргуулж авах,

в.2005 онд төрсөн 18 нас хүрсэн иргэнийг харьяа сумын бүртгэл явагдах байранд өөрийн биеэр ирж цэргийн бүртгэлд хамруулах,

г.E-Mongolia цахим бүртгэл 2025 оны 01 дүгээр сарын 08-10-ныг хүртэл явагдах тул бүртгэлд хамрагдаж, бүртгүүлсэн тухайгаа багийн Засаг даргадаа мэдэгдэх,

д.Албан байгууллагадаа ажиллаж байгаа 18-50 насны эрэгтэй ажилчин, албан хаагчдын нэрийн бүртгэлээр бүртгэлийн ажлыг явуулж, мэдээ, тайланг 2025 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Цэргийн штабт ирүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

4.Цэргийн тоо бүртгэлийн арга хэмжээнд зориулж үндэсний бөхийн барилдаан зохион байгуулж явуулахыг Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга С.Энх-Амгалан, Асгамба 3 дугаар багийн Засаг дарга М.Сэр-Од нарт хариуцуулсугай.

5.Цэргийн тоо бүртгэлийн зардал 200,000 (Хоёр зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн), Нягтлан бодогч (Л.Алимаа) нарт зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ



